БАТЛАВ

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АРХИТЕКТУР ЗОХИОМЖЛОХ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 22-ны өдөр № 2024/03-07 Улаанбаатар хот

Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагууд нь онц чухал ангилалд хамаардаг мэдээллийн дэд бүтэцтэй тул төрийн энтерпрайз архитектурын (ТЭА) аюулгүй байдалыг архитектурыг (АБА) хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдалд шууд нөлөөлөх эрсдэлийг байнга тодорхойлох, үнэлэх, боловсруулах, бууруулах, гадаад болон дотоод халдлага, аюул занал, тохиолдох магадлал, эмзэг байдлын түвшинг тогтоох, түүнээс үүсэх үр дагавар, хор уршигийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох шаардлага байнга тулгардаг. Яам, түүний харьяа байгууллагуудад аюулгүй байдалын архитектур, эрсдэлийн удирдлагын болон мэдээллийн аюулгүй байдалын удирдлагын тогтолцоо (МАБУТ) хараахан бүрэлдэн тогтоогүй учир кибер аюулгүй байдлын хууль тогтоомж, холбогдох журам, стандартад яам, харьяа байгууллагын удирдлагын тогтолцоо, МТ-ийн дэд бүтэц нийцэж буй эсэхэд шинжилгээ хийж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, ТЭА-ын аюулгүй байдалын архитектур (АБА) бий болгох, МАБУТ нэвтрүүлэх, шаардлага үүссэн. Үүний тулд иж бүрэн эрсдэлийн үнэлгээ гүйцэтгэж, үр дүнд нь суурилан яам, харьяа байгууллагын АБА -ыг зохиомжилж төлөвлөх, МАБУТ-г нэвтрүүлж төлөвшүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бий болгох цаг үеийн болон эрх зүйн шаардлага тулгарч байна. Тиймээс эдгээр ажлыг "Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
Зөвлөх үйлчилгээний зорилго	Зам, тээврийн хөгжлийн яам болон "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын АБА-ыг зохиомжилж төлөвлөх, МАБУТ-г бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц болон ашиглаж буй бүх системд иж бүрэн эрсдэлийн үнэлгээ, аудит хийж, холбогдох стандартыг нэвтрүүлж, дүрэм журмыг боловсруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, соёлыг

	төлөвшүүлэх шаардлагатай үйлчилгээг үзүүлэх
Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ	Зам, тээврийн хөгжлийн яам, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ
Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд	Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, ЗГХЭГ, Дэлхийн банкны “Төрийн энтерпрайз архитектур, өгөгдөл солилцооны нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх” төсөлийн баримт бичигүүд
Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үе шат	• Үйлчилгээний төлөвлөлт, бэлтгэл үе • Иж бүрэн эрсдэлийн үнэлгээ гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж гаргах • Эрсдэлтэй талбаруудад нэвтрүүлэх удирдлагын болон технологийн хяналт, удирдлагуудыг сонгох, төлөвлөх • МАБ-ын бодлого, хяналтуудыг сонгох, нэвтрүүлэх, боловсруулах, бусад бодлого, журам дүрмийг боловсруулах, баримт бичиг боловсруулах • АБА-ыг зохиомжлох болон МАБУТ-г хэрэгжүүлэх, нэвтрүүлэх • МАБУТ-ны хэрэгжилтийг үнэлэх, хэмжих, хянах хэрэгсэл, маягтуудыг боловсруулах • Хүний нөөцийг сургах, хөгжүүлэх, МАБУТ-г хэвшүүлэх, засах, залруулах • АБА-ыг төлөвлөх, хэрэгжүүлж эхлэх • Тайлагнах, баталгаажуулах,
Зөвлөх үйлчилгээний баримт бичгийн бүрдэл	• Ажлын даалгавар, • Үнийн саналууд, • Гэрээ, тайлангууд, сургалтын материалууд, акт
Зөвлөх үйлчилгээний ажил, үүрэг	• Мэдээллийн технологи, аюулгүй байдлын иж бүрэн эрсдэлийн үнэлгээ гүйцэтгэх • Мэдээллийн болон кибер аюулгүй байдлын төрөл бүрийн нэвтрэх тест гүйцэтгэх • Шаардлагатай бол МАБ-ын аудит гүйцэтгэх • Яамны МАБ-ын болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудитын үр дүнд суурилан ТЭА-ын АБА-ыг зохиомжлох, ISO27001:2022 стандартад тусгасан хяналт, удирдлагыг сонгох, хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж гаргах • Яамны мэдээллийн аюулгүй байдлын архитектур, удирдлагын тогтолцоог бий болгох, дэмжих бодлого, журмууд боловсруулах • Зам, тээврийн хөгжлийн төвийн МАБ-ын болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудитын үр дүнд суурилан ТЭА-ын АБА-ыг зохиомжлох, ISO27001:2022 стандартад тусгасан хяналт, удирдлагыг сонгох, хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж гаргах • Зам, тээврийн хөгжлийн төвийн мэдээллийн аюулгүй

	байдлын архитектур, удирдлагын тогтолцоог бий болгох, дэмжих бодлого, журмууд боловсруулах • Олон улс, улсын чанартай авто замын төлбөр авах үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн системд мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ, аудит үнэлгээг хийх • Яамны болон төвийн мэдээллийн аюулгүй байдлын архитектурыг бий болгох төлөвлөгөө боловсруулах, эхний шатны хэрэгжүүлэлтийг гүйцэтгэх. • Яамны болон төвийн МАБУТ-г удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, бодитоор нэвтрүүлэх, • АБА болон МАБ-ын хамаарах сургалтууд зохион байгуулах, хэмжих, үнэлэх, хянах хэрэгсэл, маягтууд боловсруулж ашиглах • Дотоод аудиторууд, МАБ-ын ажилтныг сурган хөгжүүлэх • Яамны болон төвийн АБА, МАБУТ-ны хэрэгжилтэд үнэлгээ хийх, засах залруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд зөвлөх
Санал болгож буй арга зүй	Боломжит бүх арга зүйг ашиглана.
Зөвлөх үйлчилгээний үр дүн	• ТЭА-ын Аюулгүй байдалын архитектурын зохиомж бий болж, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулагдана. Төлөвлөгөөний дагуу эхний жилд хийгдэх ажил, худалдан авалт хийгдэнэ. • ISO27001:2022 стандартад нийцсэн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо төлөвшинө. • Үндэсний аюулгүй байдлыг хангах, Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах баталгаа бий болно. • Төрийн яам, харьяа байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг байнга бодитоор үнэлэх, эрсдэлийн үнэлгээ, дотоод аудитыг төлөвшүүлэх, шаардлагатай арга хэмжээг түргэн шуурхай авах, хариу үйлдэл хийх боломж бүрдүүлнэ. • Мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн болон дотоод хяналт, аудитын тогтолцоо, эрсдэлийн удирдлага бий болгоно. • Төрийн жинхэнэ албан хаагчид мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, хамгаалалтын талаар мэдлэг, чадвар, туршлагатай болж аюулгүй зохистой хэрэглээний соёл төлөвшинө. • Төрийн цахим үйлчилгээ чанартай, тасралтгүй, шуурхай, баталгаатай болно • Дэлхий нийтээр нэг мөр хэрэглэдэг ISO27000 серийн Мэдээллийн аюулгүй байдлын багц стандартын шаардлага хангагдах суурь тавигдана • Нийтийн түлхүүрийн дэд бүтэц нэвтрүүлэх бааз суурь бий болно. • Мэдээллийн аюулгүй байдлын мэргэшсэн ажилтныг хөгжүүлж чадавхыг сайжруулна.

Зөвлөх үйлчилгээний онцгой нөхцөл	• Төсөл 2022-2025 онд зам, тээврийн салбарт иж бүрэн хэрэгжиж дуусах бөгөөд 2022 онд салбарын норм нормативын сангийн төлөвлөгөөнд тусгагдан санхүүжилт шийдвэрлүүлнэ. • Эрсдэлийн үнэлгээ, аудитын дүгнэлт болон АБА-ын зохиомжийг харгалзан үзэж зайлшгүй шаардлагатай хамгаалалтын техник хэрэгсэл, программ хангамж, лицензийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлно. • Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд мөрдөгдөх дүрэм журмын хэрэгжилтийг хангах, дотооддоо болон салбарын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам боловсруулж мөрдүүлж эхэлнэ. • Төслийн боловсруулалтын явцад холбогдох инженер техникийн ажилтнуудад сургалт зохион байгуулах, нийт албан хаагчдын дунд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	100.000.000/ Зуун сая төгрөг/
Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 1 жил 2 сар үргэлжилнэ
Захиалагч байгууллага	Зам, тээврийн хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн төв
Гүйцэтгэх байгууллага	Төсөл гүйцэтгэх чанарын үнэлгээгээрээ хамгийн сайн үнэлэгдсэн бөгөөд төсөвт багтсан үнийн санал өгч хамгийн сайн үнэлэгдсэн байгууллага
Зөвшилцөх байгууллага	Тагнуулын ерөнхий газрын харьяа Мэдээллийн аюулгүй байдлын газар
Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх багт тавигдах шаардлага	• Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан, мэдээлэлийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн аж ахуй нэгж, байгууллага байх; • МАБ, ISO27000 серийн стандартаар мэргэшсэн, мэргэжлийн өндөр төвшний сургалт, зөвлөгөө өгөх, аудит хийх туршлага, чадвартай 3-аас доошгүй мэргэжилтэн, шинжээчийн бүрэлдэхүүнтэй төслийн багтай байх • Багийн ахлагч нь ISO27001 стандартын тэргүүлэх аудиторын гэрчилгээтэй байх. • Багийн ахлагч нь төрийн энтерпрайз архитектурын аюулгүй байдлын архитекторын чиглэлээр сайн мэдлэгтэй байх. • Багийн ахлагч нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны зөвлөх үйлчилгээ үзүүлж туршлагатай байх • Багийн ахлагч болон гишүүд ISO27001 стандартыг 2-оос доошгүй байгууллагад амжилттай нэвтрүүлэн хэрэгжүүлсэн туршлагатай байх Зөвлөх багийн 2-оос доошгүй гишүүн МАБ, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийж байсан туршлагатай байх. • Зөвлөх нь гүйцэтгэхээр санал ирүүлсэн үйл ажиллагаагаа гэрээ байгуулснаас хойш 1 жил 2 сар

	үргэлжлэх боломжийг бүрдүүлсэн байх; • Зөвлөхийн баг өрөө, ажлын байр, хаяг, утас, факстай байх; • Зөвлөх нь ажлын даалгаварт заасан бүх шаардлагуудыг нэг бүрчлэн хангасан, бүх үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд явуулахыг батлан харуулсан материалыг ирүүлнэ. • Аудитын олон улсын стандартын шаардлага хангасан, аудиторын мэргэжлийн ёс зүйг дагаж мөрддөг байх.
Сургалт зохион байгуулах багт тавигдах шаардлага	• ISO27001 стандарт, МАБ, кибер аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулсан туршлагатай байх; • Сургалтын материал, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх; • Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөртэй байх, сургалтад ашиглагддаг сүүлийн үеийн заах арга зүй, арга хэрэгслүүдтэй байх ; • Сургалт зөвлөгөөний тараах материал, видео хичээл, мэдээллийн хуудас, ном, гарын авлагаар хангах боломжтой байх;

ХЯНАСАН:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга — Д.БАЗАРСАД

БОЛОВСРУУЛСАН:

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн — Г.АНХЦЭЦЭГ